

## МАНЖААС ХҮРЭЭНД ЯВУУЛСАН ШИНЭ ЗАСГИЙН БОДЛОГО, ТҮҮНИЙ БҮТЭЛГҮЙТЛИЙН ШАЛТГААН (Товчлол)

Чэнь Вэйсинь\*

Хар тамхины дайн дэгдсэнээс хойш, гадаадын хүчнүүд Хятадад орж, улмаар гадаадын хүчнүүд Хятадад орж, улмаар энэ түрэмгийлэл нь Монгол газар хүрч, хүчирхэг гүрнүүд Монголд ашиг сонирхолдоо хөтлөгдөн аажмаар харилцан сүлбэлдэж байв. Монгол Чин улсын засгийн газар нь хуучин ноёрхох байдлаа хадгалсаныг бодсон ч монголын нийгмийн байдал ийм бололцоог олгосонгүй. Манж Чин улсын засгийн газар Монголд ноёрхох бодлогоо өөрчилөхгүй гэж бодож байсан ч засаг захиргааны арга хэмжээ авч, монголчуудын амьдралыг сайжруулах биш, харин Монгол дахь хүчин чадлаа зузаатган, эцсийн дүндээ Монголыг гадныханы гарт оруулах бодлого баримтласан юм. “Шинэ засгийн бодлого” бол ийм нөхцөлд Монголд их хүчээр нэвтрэн орох явдал байв.

Манжийн засгийн газраас Монголд явуулсан шинэ засгийн бодлогын уг санаа нь дараахь болно. Үүнд:

1. Монголын байгаа засаг захиргааны систем өнөөгийн шаардлагад нийцэхгүй гэж үзсэн.

2. Хүчирхийлэл, түрэмгийлэл хийх.

3. Олон үндэстэн ард түмний дургүйцэл, эсэргүүцлийг дарах

4. Гадаад гүрнүүд Хятадыг хүчирхийлэх, харгислах гэсэн санаархлыг болиулах явдал юм.

Бадаргуулт төрийн 26 оны 12-р сард Манжийн засгийн газраас гаргасан зарлиг нь цэргийн бэлтгэлийг бүхэлд нь сайжруулах, баян чинээлэгчүүдийг дэмжих, хүмүүсийг бэлтгэн хүмүүжүүлэх, Манжийн засаглал, феодалын ноёрхол эрхийг улам бататган бэхжүүлэхийн төлөө ч байв. Харин Монгол нутагт хуучин бодлогоо сэргээх, Орос, Япон зэрэг орон Монголд түрэмгийлэлийг зогсоохын төлөө байв.

Иймээс уламжлалт аймаг хошууны бодлого, засаг захиргааны байгуулал, цэрэг захиргааны бүтцийг өөрчилөхийн төлөө байв. Манжийн засгийн газрын Монголд хэрэгжүүлж байсан шинэ засгийн бодлого нь Манжийн засгийн газрын Монгол дахь ноёрхолоо бэхжүүлж, эд баялаг, улсын сан хөмрөгийг ашиглах явдал байлаа.

\* Чэнь Вэйсинь - Хааны ордон музейн парламенттай холбоо барих гишүүн, Хятадын соёлын их сургуулийн улс төрийн бодлогын хүрээлэнгийн докторант

Тухайн үед Манжийн засгийн газар юуны өмнө Лифань Юань-ийг (хязгаар орныг хамаарах зөвлөл) Ли фаньбу-Яам болгож, Чин улсын засгийн газраас мал аж ахуй, тариалан эрхлэх, төмөр зам, уурхай, ой мод, загас агнуур, сургууль, худалдаа, цэргийн алба зэрэг 14 зүйлийг хамааран шалган хянаж байхаар тогтож, улмаар ордны том түшмэдийг Монголд илгээж байцаан үзүүлжээ. Үүнээс хойш, Зүүн хойт, Баруун хойт Хятад, Монгол зэрэг газарт суугаа жанжин, амбан сайд зэргийн хил хязгаарын түшмэдүүд Чин улсын засгийн газарт элдвийн санал дэвшүүлэх болов. Бас Монголын зарим ноёд Манжийн засгийн газар санал дэвшүүлж, шинэ засгийн бодлогыг дэлгэрүүлэхээ дэмжиж байв.

Эхлээд ордныхон Монголын аймаг хошуудыг өөрчлөн муж байгуулахаар бодсон боловч зарим жанжин, амбан нар муж байгуулах талаар санал нэг бус тул дээрхи саналыг хэрэгжүүлж чадаагүй юм. Бадаргуулт төрийн 31 онд (1905) хүрээнд суугаа манжийн амбан Тин Чжи Оросын худалдаачинтай хамтран алт олборлох, улмаар хүрээнд Монгол сургууль байгуулж, хүүхдүүдэд манж, монгол, хятад хэл бичиг үсэгт сургахаар болов.

Хэвт ёсны анхдугаар онд (1909) Тин Чжи өвчнөөр нас барж, Сандо хүрээнд суух амбан болж, шинэ засгийн бодлогыг идэвхитэй явуулав. Сандо амбан Хүрээнд суусанаас хойш Хэвт ёсны 2-р онд (1910) боловсрол, цэрэг-улс төр, худалдаа, уул уурхай, цагдаа, тамхи хориглох, зам тээврийн зэрэг олон зүйлт шинэтгэл явуулж, улмаар бэлтгэл олон арга хэмжээ авав. Сандо амбан шинэ засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд их чармайлт тавьсан төдийгүй манжийн засагт онцгой анхаарал тавьж байв.

Монголд шинэ засгийн бодлого нь эерэг, эсрэг хоёр талын нөлөө үзүүлсэн юм.

Эерэг тал нь:

1. Шинэ засгийн бодлогыг явуулсан зорилго нь гадны хүчин Монголд нэвтрэхийг хязгаарлан, Монголын хил хязгаарыг хамгаалж, бие даах эрхийг (сувернитет) бататгасан.

2. Аж үйлдвэр, худалдааг өрнүүлж, хил хязгаарын эдийн засгийн хөгжлийг ахиулж, нөөц баялагийг нэмэгдүүлж, Манжийн засгийн ордны сан хөмрөг улам бүр доройтох хямралаас гэтэлгэсэн.

3. Хүн амын шилжин суухыг чөлөөтэй болгосон нь олон үндэстэний харилцан ойртон нийлэхэд ашигтай болсон.

*Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав*